



МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирлын  
2024 оны 04 сарын 01-ний өдрийн  
А/39 дугаар тушаалын Хавсралт-1

## МОНГОЛ УЛСААС ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ ЭКСПОРТЫН БАРААНД ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (цаашид МҮХАҮТ)-аас олгох, баталгаажуулах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог хууль, олон улсын гэрээ, худалдааны дүрэм, холбогдох хууль тогтоомжоор тодорхойлсны дагуу дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

1.2.1. "Монгол улсаас гарал үүсэлтэй бараа" гэж Монгол Улсын бүрэн гарал үүсэлтэй бараа болон Монгол Улсад үйлдвэрлэлийн явцад үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн барааг ойлгоно. Үүнд:

а/ "Монголын бараа, бүтээгдэхүүн" гэж Гаалийн тухай хуулийн 3.1.2-д зааснаар Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн;

б/ Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлосон ашигт малтмал, түүхий эд, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн;

в/ Монгол Улсын нутаг дэвсгэрт ургасан ургамал болон түүнээс гаралтай бараа бүтээгдэхүүн;

г/ Монгол Улсын нутаг дэвсгэрт төрж бойжсон амьд мал, амьтан, загас болон тэдгээрээс гаралтай бараа бүтээгдэхүүн;

д/ Монгол Улсын хөлөг онгоцоор мөн түүнчлэн түрээслэн авсан хөлөг онгоцоор олборлосон далайн загас агнуурын болон далайн бусад бараа бүтээгдэхүүн;

е/ Монгол Улсын хөвөгч загасны болон түрээслэн авсан хөвөгч загасны үйлдвэрт үйлдвэрлэсэн зөвхөн энэ зүйлийн /д/-д заасан бараа бүтээгдэхүүн;

ё/ Монгол Улсын нутаг дэвсгэрээс түүхий эд болгон ашиглахаар цуглуулсан урьд нь ашиглаж байсан эд зүйлс;

ж/ Монгол Улсад явуулсан үйлдвэрлэлийн хаягдал зүйлс;

з/ Энэ зүйлийн ё болон ж заалтад дурдагдсан зөвхөн тэдгээр зүйлсээс үйлдвэрлэлийн аливаа шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн.

1.2.2. "Монгол Улсаас бүрэн гарал үүсэлтэй бараа" гэж Монгол улсад бүхэлд нь үйлдвэрлэсэн барааг;

1.2.3. “Үйлдвэрлэлийн явцад үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн бараа” гэж бараанд шинж чанарын буюу барааны уялдуулсан системийн хүрээнд өөрчлөлт гарсан, бараа үйлдвэрлэхэд зарцуулсан нэмүү өртөг (НӨ)-ийн 40-ээс дээш хувийг Монгол Улсад үйлдвэрлэсэн барааг;

1.2.4. “Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэсэн Монгол Улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүн” гэж импортын гарал үүсэлтэй түүхий эдээр Монгол Улсад эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэсэн дараах бүтээгдэхүүнийг ойлгоно. Үүнд:

а/ Монгол Улсын бүрэн гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур, бусад нэхмэлийн түүхий эдээр буюу тэдгээрээр хийсэн ээрмэл утас, даавуугаар Монгол Улсад эсгэж, сүлжиж, оёх буюу өөр аргаар холбож эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож экспортод нийлүүлэхээр савласан оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн;

б/ Импортын гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур буюу нэхмэлийн бусад түүхий эдээр Монгол улсад утас болгон ээрч, сүлжиж бэлэн бүтээгдэхүүн болгож, савлаж экспортлох сүлжмэл бүтээгдэхүүн;

в/ Импортын ээрсэн утсаар тухайн бүтээгдэхүүний үндсэн деталь хэсгүүдийг Монгол улсад сүлжиж харин бусад ажилбаруудыг өөр улсад гүйцэтгэж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгон экспортлох сүлжмэл эдлэл. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний барааны тэмдэг нь Монгол улсад бүртгэгдсэн байна;

г/ Монгол улсад эсгэсэн эсвэл эсгэсэн деталь хэсгээр Монгол улсад оруулж ирсэн деталь хэсгүүдийг Монгол улсад оёж буюу өөр аргаар нийлүүлж савлаж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож экспортлох оёмол эдлэл;

д/ Импортын гарал үүсэлтэй үс, ноос, ноолуур бусад нэхмэлийн түүхий эдээр буюу тэдгээрээр хийсэн ээрмэл утас, даавуугаар Монгол улсад эсгэж, сүлжиж, оёж буюу өөр аргаар нийлүүлж эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож экспортлох оёмол, сүлжмэл эдлэл.

1.2.5. “Гарал үүслийн гэрчилгээ” гэж МҮХАҮТ-аас экспортын барааны гарал үүслийг уг журмын дагуу тодорхойлон олгож байгаа нууцлал, үнэт цаас бүхий баримт бичгийг;

1.2.6. “Баталгаажуулах” эрх бүхий этгээдийн хүсэлтээр гарал үүслийн гэрчилгээг дахин шалгах үйл ажиллагааг;

1.2.7. “Экспортлогч” гэж экспортын барааны гарал үүслийг гэрчлүүлэхээр хүсэлт гаргасан хувь хүн, хуулийн этгээдийг;

1.2.8. “Гарал үүслийн дүрэм” гэж Олон улсын гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээрийн I хэсгийн 1 дүгээр зүйлд заасныг;

1.2.9. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” /цаашид “Уялдуулсан систем” гэж Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3.1.5-д заасныг;

1.2.10. “Гарал үүслийн бараа, бүтээгдэхүүн” гэж гарал үүслийн дүрмийн шалгуурт нийцсэн бараа, материал;

1.2.11. “CIF нийлүүлэлтийн нөхцөлийн өртөг” гэж импортын барааны тээвэрлэлт, даатгалын зардал, дотоод татварыг эс тооцвол хүчин төгөлдөр мөрдөгдөж буй худалдааны нэр томъёог тайлбарлах Олон улсын худалдааны дүрмийн (“Инкотермс”) дагуу импортлогч улсад нэвтрэх боомт буюу газар хүртэлх нийт зардал;

1.2.12. “FOB нийлүүлэлтийн нөхцөлийн өртөг” гэж импортын барааны тээвэрлэлт, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй худалдааны нэр томъёог тайлбарлах Олон улсын худалдааны дүрмийн (“Инкотермс”) дагуу импортлогч улсад нэвтрэх боомт буюу газар хүртэлх нийт зардал;

1.2.13. “EXW нөхцөлийн өртөг” гэж үйлдвэрлэгчийн нутаг дэвсгэр, агуулахад бараа, бүтээгдэхүүний эцсийн боловсруулалт, дахин боловсруулалтын шатанд бий болсон зардал (“Инкотермс”).

### **Хоёр. Экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ олгох**

2.1. Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрт заасан нөхцөл, журмыг баримтлан гэрчилнэ хэмжээ тогтоосон акт зэргийг удирдлага болгон экспортлогчийн хүсэлтийг үндэслэн холбогдох аргачлалыг ашиглан дараах тохиолдолд олгоно. Үүнд:

2.1.1. Энэхүү журмын 1.2.1-т заасан Монгол Улсаас гарал үүсэлтэй бараанд;

2.1.2. Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу тухайн импортлогч орны гаалийн тарифын хөнгөлөлтөд хамрагдах бараанд;

2.1.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр буюу бусад баримт бичигт энэ тухай дурдсан байвал;

2.1.4. Үзэсгэлэн, яармагт явуулж байгаа бараанд;

2.1.5. Тендер, худалдан авалт болон олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдсан ЖДҮ-ийн бараа, бүтээгдэхүүн;

2.1.6. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэгдсэн Монгол улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүнд.

2.2. Гарал үүслийн гэрчилгээ нь дараах төрөл байна. Үүнд:

a) **FORM A** буюу дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас гаалийн татварын хөнгөлөлт эдлэхэд хамаарах;

b) **FORM E** буюу Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн Засгийн түншлэлийн хүрээнд гаалийн татварын хөнгөлөлт эдлэхэд хамаарах;

c) **FORM APTA** буюу Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээрийн хүрээнд гаалийн татварын хөнгөлөлт эдлэхэд хамаарах;

d) **FORM B** буюу тухайн улсын зах зээлд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэггүй, зөвхөн барааны гарал үүслийг тодорхойлоход хамаарах.

2.3. Гарал үүслийн гэрчилгээ авахаар хүсэлт гаргаж буй иргэн, хуулийн этгээд нь МҮХАҮТ-ын гарал үүслийн гэрчилгээний цахим системээр холбогдох мэдээллээ үнэн зөв бөглөж урьдчилан илгээнэ.

2.4. Гарал үүслийн гэрчилгээ гаргуулах тухай хүсэлтийг бичгээр ирүүлэх ба дор дурдсан бичиг баримтыг хавсаргана.

2.4.1. гарал үүслийн гэрчилгээ авах өргөдөл;

2.4.2. аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хувь хүний хувьд иргэний үнэмлэхийн хуулбар;

2.4.3. худалдах худалдан авах гэрээний хуулбар;

2.4.4. үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын хуудас баталгаажсан гарын үсэг, тамга, тэмдэгтэй;

2.4.5. хэрэв давхар захиалгаар гүйцэтгүүлсэн тохиолдолд тухайн ажлын тухай тодорхойлолт /subcontract/;

2.4.6. шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл болон чанар, эрүүл ахуйн гэрчилгээ;

2.4.7. барааны гарал үүслийг тодорхойлох бусад нотлох баримт.

2.5. Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн экспортлогчид эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно.

2.6. Барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор шаардлагатай тохиолдолд экспортлогч талаас нэмэлт баримт бичиг гаргуулж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шошгожилт, чанарын хяналт, үйл явц, ажиллагаатай нь газар дээр нь танилцаж болно.

2.7. Гуравдагч орны нутаг дэвсгэр дээр уг бараа нь арилжааны буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дахин боловсруулалт хийгдэх бол энэ тухай гарал үүслийн гэрчилгээ авахаас өмнө мэдэгдэнэ.

2.8. Гарал үүслийг гэрчлүүлэхээр ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг экспортлогч өөрөө хариуцна.

2.9. Экспортлогч нь гарал үүслийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглох ба гэрчилгээний хадгалалт, хамгаалалтыг экспортлогч өөрөө хариуцна.

### **Гурав. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгох**

3.1. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэх бүтээгдэхүүн экспортлогч нь энэхүү журмын 1.2.4-т заасан барааны гарал үүслийг гэрчлүүлж болох ба ингэхдээ дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

3.1.1. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэх бүтээгдэхүүн экспортлогч нь экспортын гэрээг бүтээгдэхүүний загварын хамт МҮХАҮТ-д урьдчилан бүртгүүлэх;

3.1.2. Гарал үүслийн гэрчилгээ авах бүтээгдэхүүний түүхий эд, даавуу, утас буюу эсгэсэн деталь, мод бусад материалыг Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирэх тухай бүрд экспортлогч нь МҮХАҮТ-д даруй мэдэгдэж барааны гаалийн мэдүүлэг, нэхэмжлэх, сав баглаа боодлын бичиг баримтыг /англи хэл дээр/ бүртгүүлэх;

3.1.3. Бүтээгдэхүүн ачилтад бэлэн болмогц экспортлогч нь энэ тухай МҮХАҮТ-д мэдэгдэж энэхүү журмын дагуу өргөдөл болон холбогдох баримт бичгүүдийг ирүүлэх;

3.1.4. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэсэн оёмол бүтээгдэхүүн дээр хийх наалт, хатгамал зэрэг гоёлын чимэглэлийг бүтээгдэхүүний эсгэсэн деталь хэсэг дээр наах, хатгах буюу өөр аргаар деталь хэсэгтэй холбосон байна.

3.2. МҮХАҮТ нь дээрх бичиг баримтын үндсэн дээр шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх, дараа үзлэг хийж зөрчилгүй гэж үзсэн тохиолдолд энэхүү журамд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх ерөнхий зохицуулалтын дагуу гарал үүслийн гэрчилгээ олгоно.

## **Дөрөв. Гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулах**

4.1. МҮХАҮТ эрх бүхий этгээдийн хүсэлтээр гарал үүслийн гэрчилгээ, гадаад худалдаанд хэрэглэгддэг дагалдах баримт бичгийг дахин шалгах буюу баталгаажуулж болно.

4.2. Гадаад улсын худалдааг дэмжих байгууллагын олгосон гарал үүслийн гэрчилгээ, гадаад худалдаанд хэрэглэгддэг дагалдах баримт бичгийг баталгаажуулахдаа тус байгууллагын албан ёсны мэдээллийг үндэслэл болгоно.

## **Тав. Цахим гарал үүслийн гэрчилгээ**

- 5.1. Гарал үүслийн гэрчилгээг хүлээн авагч улсын холбогдох эрх бүхий байгууллагаас цаасан хэлбэрээр шаардсанаас бусад тохиолдолд МҮХАҮТ-ын гарал үүслийн гэрчилгээний систем (цаашид “цахим систем” гэх)-ээр дамжуулан цахимаар олгоно.
- 5.2. Цахим гарал үүслийн гэрчилгээ нь уг журмын 1.2.5-д заасан нууцлал, хамгаалалт бүхий үнэт цаасны шаардлагыг хангасан цахим баримт бичиг байна.
- 5.3. Цахим гарал үүслийн гэрчилгээ нь үнэт цаас бүхий цаасан хэлбэрийн гэрчилгээтэй нэгэн адил эрх зүйн хүчин төгөлдөр байна.
- 5.4. Цахим гарал үүслийн гэрчилгээ нь МҮХАҮТ-ын тусгай тэмдэг болон эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн дардсаар баталгаажсан байна.
- 5.5. Цахим гарал үүслийн гэрчилгээг экспортлогч болон хүлээн авагчид цахим шуудангаар, Монгол Улсын Гаалийн ерөнхий газарт систем холболтоор илгээх ба шаардлагатай тохиолдолд татаж авах эсвэл хэвлэн ашиглаж болно.
- 5.6. Цахим гарал үүслийн гэрчилгээг олгох, баталгаажуулах үйл явцыг Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
- 5.7. Цахим гарал үүслийн гэрчилгээний дагалдах баримт бичгийг цахим системээр бизнес эрхлэгчдээс авна.
- 5.8. Цахим гарал үүслийн гэрчилгээ болон дагалдах баримт бичгийг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн цахим хэлбэрээр 5 жилээс доошгүй хугацаанд хадгална.
- 5.9. Экспортлогчийн хүсэлтийн дагуу цахим гарал үүслийн гэрчилгээнд өмнө нь олгогдсон бүртгэлийн дугаар (Ref No)-ыг солилгүйгээр засвар, өөрчлөлт оруулж болно.
- 5.10. Гарал үүслийг тодорхойлох ажиллагааг гүйцэтгэхдээ үйлдвэрлэл, бэлтгэлийн үйл явц зэргийг дүрс бичлэг, зураг хэлбэрээр баримтжуулж болно.

*/Энэ бүлгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/156 түшаалаар нэмсэн/*

## **Зургаа. Бусад зүйл**

6.1. Танхим нь гарал үүслийг гэрчлүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш тухайн барааны гарал үүслийг энэхүү журам, холбогдох аргачлалын дагуу тодорхойлсон тохиолдолд ажлын 4 цагт багтаан гэрчилгээг олгох ба хүсэлт гаргагч нь холбогдох үйлчилгээний хураамжийг төлнө.

6.2. Гарал үүслийн гэрчилгээг Гаалийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасны дагуу нэг ачилтын бараанд олгоно.

- 6.3. Экспортлогч нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэхээр бүрдүүлэлт хийх бүрт экспортлох барааны гарал үүслийг гэрчлүүлнэ.
- 6.4. Барааны шинж чанар, овор хэмжээ, экспортын давтамж зэрэг онцгой нөхцөлөөс шалтгаалан хүсэлт гаргагч нь энэхүү журмын Хавсралт №3-т заасан хялбаршуулсан нөхцөлөөр гарал үүслийг мэдүүлж болно.
- 6.5. Гарал үүслийн гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй.
- 6.6. Экспортлогч нь барааны гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулахтай холбогдсон гомдлыг МҮХАҮТ гаргаж болно.
- 6.7. Гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлэл өгсөн, гарал үүслийг гэрчлэх, баталгаажуулах үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.8. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний гарал үүслийг энэхүү журам болон тухайн импортлогч орны гарал үүслийн дүрмийн дагуу гэрчилнэ.
- 6.9. Энэхүү журамд МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 6.10. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

-oOo-